



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК-ИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: САГ-2021/8/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх  
Аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер Д.Энхдалай  
Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn  
Аудитор П.Чанцалдулам  
Утас: 261628 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn  
Аудитыг гүйцэтгэсэн: "Лидер экаунт аудит" ХХК  
Утас: 70114519 Цахим хаяг: leaderaudit.20@gmail.com

Улаанбаатар хот  
2021 он

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	9
3.Аудитын тайлан.....	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	11
3.4. Материаллаг байдал .....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	11
3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	12
3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа .....	14
3.8. Шилэн дансны мэдээлэл.....	14
3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.10. Аудитын илрүүлэлт.....	14
Залруулсан алдаа .....	14
3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	14
4. Менежментийн захидал.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	17



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Х.АЛТАЙ ТАНАА

2024.03.15 № 07/867  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 15 зорилтын хүрээнд 30 арга хэмжээ ажил хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	953,430,215.05	554,589,808.41
1.1.2	Дансны авлага	49,651,294.32	84,130,892.90
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	367,769.00	
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	1,000,000.00	
1.1.6	Бараа материал	24,567,914.43	24,945,190.03
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	8,341,414.98	8,921,754.47
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	13,160,000.00	13,160,000.00
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>1,050,518,607.78</b>	<b>685,747,645.80</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,083,731,270.36	2,210,709,148.46
1.2.2	Биет бус хөрөнгө	653,005,365.40	561,871,087.08
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>2,736,736635.76</b>	<b>2,772,580,235.54</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,787,255,243.54</b>	<b>3,458,327,881.34</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	1,541,424,190.07	2,122,930,190.07
2.1.1.2	Цалингийн өглөг	79,758.38	
2.1.1.3	Татварын өр	13,540,647.75	9,541,742.21
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	9,763,779.67	11,921,103.77
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	40,158,128.65	60,979,514.00
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,604,966,504.52</b>	<b>2,205,372,550.05</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,604,966,504.52</b>	<b>2,205,372,550.05</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	23,130,593,600.00	23,130,593,600.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	12,362,216.67	12,362,216.67
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	446,321,902.02	446,321,902.02
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(21,406,988,978.67)	(22,336,322,387.40)
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>2,182,288,739.02</b>	<b>1,252,955,331.29</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,787,255,243.54</b>	<b>3,458,327,881.34</b>

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,474,667,220.37	1,100,104,609.43
2	Борлуулалтын өртөг		
3	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>1,474,667,220.37</b>	<b>1,100,104,609.43</b>
5	Хүүгийн орлого	69,083,423.93	20,003,103.96
8	Бусад орлого	5,441,775.00	4,559,025.45
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,605,000,415.07	2,088,545,238.55
12	Бусад зардал	60,352,753.15	12,682,920.88
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(33,149,154.37)	(59,244,602.02)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	1,150,000.00	
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал)</b>	<b>(1,148,159,903.29)</b>	<b>(1,035,806,022.60)</b>
19	Орлогын татварын зардал	6,891,592.39	1,988,516.57
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(1,155,051,495.68)</b>	<b>(1,037,794,539.17)</b>
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(1,155,051,495.68)</b>	<b>(1,037,794,539.17)</b>

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	/төгрөгөөр/
					Нийт дүн
<b>2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>23,130,593,600.00</b>	<b>12,362,216.67</b>	<b>446,321,902.02</b>	<b>(20,251,937,483.99)</b>	<b>3,337,340,234.70</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(1,155,051,495.68)	<b>(1,155,051,495.68)</b>
<b>2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>23,130,593,600.00</b>	<b>12,362,216.67</b>	<b>446,321,902.02</b>	<b>(21,406,988,979.67)</b>	<b>2,182,288,739.02</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				108,461,131.44	<b>108,461,131.44</b>
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>23,130,593,600.00</b>	<b>12,362,216.67</b>	<b>446,321,902.02</b>	<b>(21,298,527,848.23)</b>	<b>2,290,749,870.46</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(1,037,794,539.17)	<b>(1,037,794,539.17)</b>
<b>2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>23,130,593,600.00</b>	<b>12,362,216.67</b>	<b>446,321,902.02</b>	<b>(22,336,322,387.40)</b>	<b>1,252,955,331.29</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>1,880,614,448.38</b>	<b>1,194,532,385.39</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,344,364,308.03	1,021,521,426.51
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,415,616.00	4,660,101.23
	Бусад мөнгөн орлого	534,834,524.35	168,350,857.65
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>1,648,655,765.97</b>	<b>1,263,061,226.89</b>
	Ажиллагчдад төлсөн	660,020,444.13	611,476,433.08
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	166,466,289.35	181,230,650.38
	Бараа материал худалдан авахад төлсөн	40,975,964.00	22,173,545.00
	Ашиглалтын зардалд төлсөн	89,714,366.40	44,480,193.75
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	10,165,800.00	5,564,500.00
	Татварын байгууллагад төлсөн	280,383,901.18	162,774,258.68
	Бусад мөнгөн зарлага	400,929,000.91	235,361,646.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<b>231,958,682.41</b>	<b>(68,528,841.50)</b>
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>166,500.01</b>	<b>1,116,938.36</b>
	Хүлээн авсан хүүгийн орлого	166,500.01	1,116,938.36
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>109,081,150.00</b>	<b>331,428,503.50</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	16,092,980.00	331,428,503.50
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	92,988,170.00	
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<b>(108,914,649.99)</b>	<b>(330,311,565.14)</b>
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	<b>123,044,032.42</b>	<b>(398,840,406.64)</b>
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<b>830,386,182.63</b>	<b>953,430,215.05</b>
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<b>953,430,215.05</b>	<b>554,589,808.41</b>

## 2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	2019 оны гүйцэтгэл	2020 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>A</b>	<b>Үйл ажиллагааны нийт орлого:</b>	<b>1,550,342,419.00</b>	<b>2,390,052,610.00</b>	<b>1,124,666,738.85</b>	<b>1,265,385,871.15</b>	<b>47.1</b>
1	Арилжааны шимтгэл	791,955,784.29	945,310,345.00	400,060,602.00	545,249,743.00	42.3
2	Жилийн хураамж, үйлчилгээний хөлс	487,403,373.52	1,115,214,347.00	487,951,681.00	627,262,666.00	43.7
3	Бусад	270,983,261.48	329,527,918.00	236,654,455.85	92,873,462.15	71.8
<b>B</b>	<b>Үйл ажиллагааны нийт зардал</b>	<b>1,403,149,871.88</b>	<b>1,625,285,197.00</b>	<b>1,317,245,293.45</b>	<b>308,039,903.55</b>	<b>81.0</b>
1	үйл ажиллагааны зардал	1,156,344,896.88	1,222,958,421.00	1,051,178,071.45	171,780,349.55	85.9
2	Элэгдлийн зардал	246,804,975.00	402,326,776.00	266,067,222.00	136,259,554.00	66.1
<b>B</b>	<b>Үйл ажиллагааны ашиг (алдагдал)</b>	<b>147,193,607.71</b>	<b>764,767,412.00</b>	<b>(192,578,555.60)</b>	<b>957,345,967.60</b>	<b>-25.1</b>
1	Милленнеум Ай Ти системийн зардал	1,295,353,511.00	1,216,652,000.00	843,227,467.00	373,424,533.00	69.3
2	Татварын өмнөх ашиг (алдагдал)	(1,148,159,903.29)	(451,884,588.00)	(1,035,806,022.60)	583,921,434.60	229.2
3	Орлогын татвар	6,891,592.39	3,446,000.00	1,988,516.57	1,457,483.43	57.7
4	Татварын дараах цэвэр ашиг (алдагдал)	(1,155,051,495.68)	(455,330,588.00)	(1,037,794,539.17)	582,463,951.17	227.9
5	Нийт авлага /цэвэр/	49,651,294.32	57,633,000.00	84,130,892.90	(26,497,892.9)	145.9
6	Нийт өглөг /Милленнеум Ай Ти системийн зардал орсноор/	1,595,202,724.85	746,700,000.00	2,193,451,446.28	(1,446,751,446.28)	293.7
7	Ажиллагсдын тоо	52	55	53	2	96.3
8	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох үйл ажиллагааны зардал	0.91	0.68	1.12	(0.44)	164.7
9	Хөрөнгө оруулалт	299,653,830.00	205,098,000.00	147,764,604.00	57,333,396.00	72.0

### 3. Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Х.Алтай танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдийн хөрөнгөд бүртгэлтэй боловч байгууллагын эзэмшилд биетээр байхгүй хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 15-наас 2021 оны 03 дугаар сарын 11-ний хооронд Лидер экаунт аудит ХХК-ийн аудитор П.Шаравхорол, аудитор И.Юмчиндулам, аудиторын туслах О.Мөнхтуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Монголын хөрөнгийн бирж ТӨХК нь 2020 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 01/72 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчит хувьцаат компани гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшдэг бөгөөд хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь Засгийн газраас эрх олгосон Сангийн яам байна.

Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Үнэт цаасны арилжаа эрхлэх;
- Брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий компанийг гишүүнээр элсүүлэх, гишүүнийг түдгэлзүүлэх, гишүүнээс хасах;
- Олон нийтэд үнэт цаасны зах зээлийн талаар анхан шатны мэдлэг олгох сургалт зохион байгуулах.

Үнэт цаас, хөрөнгийн зах зээлийг идэвхжүүлэх, шинээр болон нэмж үнэт цаас гаргах зорилтын хүрээнд үнэт цаасны төлбөр тооцооны T+2 системд шилжиж, анх удаа хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас бүртгэгдэн, 65,000.3 сая төгрөгийн үнэт цаас арилжаалагдсан байна.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 15 зорилтын хүрээнд 30 арга хэмжээ ажил хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд томоохон өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Монголын хөрөнгийн бирж ТӨХК нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт 2016 оноос хойш нэмэлт өөрчлөлт хийгээгүй нь мөрдөгдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэхгүй байна.

Тайлант онд тус байгууллагын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд Сангийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас дотоод аудит, хяналт шалгалт хийгээгүй байна.

Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 2,672.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 53.4 сая төгрөгөөр тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 2,162.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 43.2 сая төгрөгөөр тогтоосон.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 328.9 сая төгрөгөөр буюу 8.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	953.4	554.6	(398.8)
Авлага	50.0	84.1	34.1
Бусад санхүүгийн хөрөнгө	1.0	-	(1.0)
Урьдчилгаа	8.3	8.9	0.6
Бараа материал	24.6	24.9	0.3

Бусад эргэлтийн хөрөнгө	13.1	13.1	-
Үндсэн хөрөнгө	2,083.8	2,210.8	127.0
Биет бус хөрөнгө	653.0	561.9	(91.1)
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>3,787.2</b>	<b>3,458.3</b>	<b>(328.9)</b>
Өр төлбөр	1,604.9	2,205.4	600.5
Эздийн өмч	2,182.3	1,252.9	(929.4)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,787.2</b>	<b>3,458.3</b>	<b>(328.9)</b>

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 554.6 сая төгрөг болж, 398.8 сая төгрөгөөр буурсан нь Лондонгийн хөрөнгийн бирж группэд Милленнеум Ай Ти системийн төлбөр 35.0 мянган ам.доллар буюу 99.7 сая төгрөгийн төлбөр төлсөн, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 331.4 сая төгрөгийн лицензийн төлбөр, Милленнеум Ай Ти системийн сервер, сүлжээний хадгалах төхөөрөмж зэргийг худалдан авснаас голлон нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэл 84.1 сая төгрөг болж өмнөх оноос 34.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь бүртгэлтэй болон гишүүн компаниудын төлөгдөөгүй гишүүний жилийн хураамж байна.

Авлага дансны үлдэгдэлд хугацаа хэтэрсэн авлага 10.9 сая төгрөг, төлөгдөх хугацаандаа байгаа авлагын хэмжээ 73.2 сая төгрөг байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 127.0 сая төгрөгөөр өссөн нь 219.5 сая төгрөгийн Милленнеум Ай Ти системийн сервер, сүлжээний хадгалах төхөөрөмж худалдан авч, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А-1/2307 дугаар шийдвэрийн дагуу 63 нэр төрлийн 44.3 сая төгрөгийн хөрөнгө акталсан зэргээс шалтгаалжээ.

Биет бус хөрөнгө 561.9 сая төгрөг болж, 91.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардлаар буурч, Oracle лицензийн сунгалтыг 111.9 сая төгрөгөөр нэмж бүртгэсэн зэргээс нөлөөлжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 2,205.4 сая төгрөг болж, 600.5 сая төгрөгөөр өссөн нь Лондонгийн хөрөнгийн бирж группэд төлөх Милленнеум Ай Ти системийн үйлчилгээний 2020 оны гэрээний хугацаанд ногдох өглөгийг хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 1,252.9 сая төгрөг болж 929.4 сая төгрөгөөр буурсан нь 1,037.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан, биет бус хөрөнгийн элэгдлийн зардлыг тооцож, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн залруулга 108.4 сая төгрөг хийснээс шалтгаалжээ.

### 3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нь байгууллагын санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.



Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2020 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 2020/16 тоот тогтоолоор 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 2,390.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,625.2 сая төгрөгөөр, алдагдлыг 451.8 сая төгрөгөөр тогтоосон байна. Хөрөнгө оруулалтын 3 арга хэмжээнд 205.1 сая төгрөгийг төлөвлөж, гүйцэтгэлээр 147.8 сая төгрөг болж, төлөвлөгөө 72 хувийн биелэлттэй байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг алдагдалтай баталсан нь Лондонгийн хөрөнгийн бирж группэд төлөх Милленнеум Ай Ти системийн ашиглалтын зардалд 1,216.6 сая төгрөг төлөвлөсөнтэй холбоотой байна.

Гүйцэтгэлээр 1,124.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,088.5 сая төгрөгийн зардал гаргаж, 1,035.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Орлогын эх үүсвэр нь арилжааны шимтгэлийн орлого 400.6 сая төгрөг, жилийн хураамж, үйлчилгээний хөлс 487.9 сая төгрөг, бусад орлого 236.6 сая төгрөгөөс бүрджээ.

Хүснэгт 1. 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	2019 оны гүйцэтгэл	2020 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>A</b>	<b>Үйл ажиллагааны нийт орлого</b>	<b>1,550.3</b>	<b>2,390.0</b>	<b>1,124.6</b>	<b>1,265.4</b>	<b>47.1</b>
1	Арилжааны шимтгэл	792.0	945.3	400.1	545.2	42.3
2	Жилийн хураамж, үйлчилгээний хөлс	487.4	1,115.2	487.9	627.3	43.7
3	Бусад	270.9	329.5	236.6	92.9	71.8
<b>B</b>	<b>Үйл ажиллагааны нийт зардал</b>	<b>1,403.1</b>	<b>1,625.3</b>	<b>1,317.2</b>	<b>308.1</b>	<b>81.0</b>
1	үйл ажиллагааны зардал	1,156.3	1,223.0	1,051.1	171.9	85.9
2	Элэгдлийн зардал	246.8	402.3	266.1	136.2	66.1
<b>B</b>	<b>Үйл ажиллагааны ашиг/алдагдал</b>	<b>147.2</b>	<b>764.7</b>	<b>(192.6)</b>	<b>957.3</b>	<b>-25.1</b>
1	Милленнеум Ай Ти системийн зардал	1,295.3	1,216.5	843.2	373.4	69.3
2	Татварын өмнөх ашиг (алдагдал)	(1,148.1)	(451.9)	(1,035.8)	583.9	229.2

Нийт орлогын гүйцэтгэл 1,124.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,265.4 сая төгрөг буюу 52.9 хувиар тасарсан нь Ковид цар тахлын улмаас арилжааны шимтгэлийн орлого 545.2 сая төгрөг, хураамж, үйлчилгээний орлого 627.2 сая төгрөгөөр тус тус тасарснаас шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 2,160.4 сая төгрөг (Милленнеум Ай Ти системийн зардал орсноор) болж, төлөвлөснөөс 681.4 сая төгрөг буюу 76.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант онд алдагдал 1,035.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 583.9 сая төгрөгөөр илүү байгаа нь үйл ажиллагааны орлого 52.9 хувиар дутуу биелсэн, зардал 24.0 хувиар зарцуулагдаагүй зэргээс шалтгаалж байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

Төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасны дагуу Сангийн яам, Хувьцаа эзэмшигчдийн төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч 6, хараат бус 3, нийт 9 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2020 онд 12 удаа зохион байгуулж 26 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

2020 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны зардалд нийт 61.6 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 56.8 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд: Цалин, урамшууллын зардалд 50.3 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 6.2 сая төгрөг, бичиг хэрэг болон бусад зардалд 0.3 сая төгрөгийн зардлыг тус тус санхүүжүүлсэн байна.

### 3.8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 61 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

### 3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 6.6 сая төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

### 3.10. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 8.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 6.6 сая төгрөгийн алдааг залруулж, 1.6 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилттэй холбоотой дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Өмнөх аудиторын зөвлөмжөөр гэрээний дагуу санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөх өглөгийн дүнг 6.6 сая төгрөгөөр дутуу бүртгэснийг залруулав.

### 3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал гараагүй байна.



#### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### **1. Балансын данстай холбоотой асуудал**

###### **1.1. Илрүүлэлт:**

Байгууллагын үндсэн хөрөнгөд өмчлөх эрх нь бусдад шилжсэн Хан-Уул дүүргийн 4-р хороо, Арцатын 1-р гудамжны 34 тоот хаягт байрлах 1.6 сая төгрөгийн үнэ бүхий хашаа байшин бүртгэлтэй байна. Энэ нь санхүүгийн тайлангийн бодитой оршин байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

###### **1.2. Эрсдэл:**

Бүртгэлд байгаа хөрөнгө байгууллагын эзэмшилд биетээр байхгүй байх;

###### **1.3. Өгсөн зөвлөмж**

Эзэмших эрх нь бусдад шилжсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт танилцуулж шийдвэр гаргуулах;

###### **1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

##### **2. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлийн асуудал**

###### **2.1. Илрүүлэлт:**

Байгууллагад ашиглагдаж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт 2016 оноос хойш нэмэлт өөрчлөлт хийгдээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

###### **2.2. Эрсдэл:**

Шинээр батлагдсан хууль тогтоомж, стандартыг биелүүлэхгүй байх, зөрчих, санхүү бүртгэлийн үйл ажиллагаа доголдох;

###### **2.3. Өгсөн зөвлөмж**

НБББББ-ийг шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөх, байгууллагын онцлогт тохирсон тусгай бодлогуудыг уг баримт бичигт тусгах;

###### **2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

НБББББ-ийг шинэчлэн боловсруулж мөрдөн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК-ИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ	МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК-ИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ	МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК-ИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ	МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК-ИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ
---	---	---	---

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК-ИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ	МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК-ИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ	МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК-ИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ	МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК-ИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ
---	---	---	---

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: <b>2020</b>	Аудитын нэр: <b>Монголын хөрөнгийн бирж ТӨХК 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит</b>	Аудитын код: <b>САГ-2021/8/СТА-ТӨҮГ</b>
Шалгагдсан байгууллагын нэр: <b>Лидер экаунт аудит ХХК</b>	Сая төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Үндсэн хөрөнгөд өмчлөх эрх нь бусдад шилжсэн хөрөнгө бүртгэлтэй байна.	1.6	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Х.Алтай С.Алтаннамар
2	Монголын хөрөнгийн бирж ТӨХК-д ашиглагдаж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт 2016 оноос хойш нэмэлт өөрчлөлт хийгдээгүй байна.	0	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Х.Алтай С.Алтаннамар
<b>ДҮН</b>		<b>1.6</b>			

2. Тайланг хуульчид хэргэ

ЭТ/МОНГОЛ

Утас: +976 51 261585  
Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: [info@audit.gov.mn](mailto:info@audit.gov.mn)  
Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Хаяг: Засгийн газрын IV байр  
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг  
Улаанбаатар-15160, Монгол Улс